



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК




САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ДААТГАЛ

Улаанбаатар хот

2022 он



Хүснэгт 1.1. Санхүүгийн байгууллагууд





Монголбанк

Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ. Монгол Улсын Төв банкныг Монголбанк гэж нэрлэнэ. Монголбанкны төв нь Монгол Улсын нийслэлд байрлана. Монголбанк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд мөн. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдал (Үүнийг иргэдийн орлогын баталгаа буюу үнийн тогтвортой байдал гэж ойлгох ба валютын ханш тогтох нь Монголбанкнаас шууд хамаарахгүй)-ыг хангахад оршино. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.


Сангийн яам

Сангийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татварын таатай орчин бүрдүүлэх, санхүү, эдийн засгийн оновчтой удирдлагаар хангахад оршино.

Санхүүгийн Зохицуулах Хороо

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага билээ.




Мөн Хороо нь холбогдох хуулийн хэрэгжилт болоод өөрийн үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнадаг, түүний харъяа байгууллага юм.



Хадгаламжийн даатгалын корпораци

Монгол Улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, банкны салбарын харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэх итгэлийг бэхжүүлэх, эрхэм зорилго бүхий олон улсын стандарт шаардлагад нийцэж, хүлээн зөвшөөрөгдсөн хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад оршино.

Зорилт:

-  Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах замаар иргэдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх
-  Банкны үйл ажиллагааны сахилга батыг сайжруулах
-  Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах






Банк

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө болон харилцагчдын итгэж хадгалуулсан мөнгийг бусдад зээлдүүлэх, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлах үйл ажиллагаа явуулдаг Монголбанкнаас зөвшөөрөл авсан ашгийн төлөө байгууллага.

Монголын банкны холбоо

Монголын Банкны Холбоо нь Монголбанкнаас албан ёсоор зөвшөөрөл авч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа банкны болон бусад санхүүгийн байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, гишүүддээ үйлчилдэг, хараат бус, бие даасан, ашгийн бус төрийн бус байгууллага юм.

Үндсэн зорилт

-  Нийт гишүүдийн хууль ёсны, нийтлэг ашиг сонирхол, эрхийг төлөөлөн хамгаалах;
-  Банк, санхүүгийн салбарын өмнө тулгарсан бодлогын асуудал, түүний оновчтой шийдэл рүү нийт гишүүдийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх;
-  Санхүүгийн салбарын үр ашигтай, эрүүл хөгжилд манлайлж, гишүүдийн оролцоо, бусад бодит хувь нэмрийг татан оруулах юм;




Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)

Өөрийн эзэмшигчдийн хөрөнгөөр зээл олгохоос гадна валют арилжаа, төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга хийх үндсэн үйл ажиллагаа явуулдаг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос зөвшөөрөл авсан ашгийн төлөө байгууллага.



Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)

Зөвхөн ХЗХ-ны гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлдэг байгууллага юм. ХЗХ-ны хөрөнгө нь гишүүдийн хадгаламжаас бүрддэг.



Даатгалын компани

Ирээдүйд учирч болох санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор гэрээгээр тохирсон нөхөн төлбөр авах хэлцэл юм. Үүнд албан журмын /жолоочийн хариуцлага/ болон сайн дурын даатгал /амь нас, эд хөрөнгө, бизнесийн үйл ажиллагааны тасалдлын, бусдад учруулсан хохирол/ зэрэг даатгалыг хамруулдаг.



Монголын даатгалын холбоо

Монгол улсын даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг хангахад даатгалын компаниудын оролцоог нэгтгэх, холбоогоор дамжуулан даатгагчдын болон олон нийтийн эрх ашгийг хамгаалах, даатгалын зах зээлийн өсөлт, хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, мэргэжлийн сургалт судалгааны тусалцааг үзүүлэхэд Монголын даатгагчдын холбоо ажилладаг.



Брокер, дилер, андеррайтерийн компани (ҮЦК)

Харилцагчийн нэрийн өмнөөс үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээ нь үнэт цаасны брокерийн компанийн үндсэн үйл ажиллагаа юм.

Харин ҮЦК өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагаа нь дилерийн компанийн үйл ажиллагаанд хамаарна.

Хөрөнгийн зах зээл дээр компанийн хувьцаа гаргах, санхүүжилтийн эх үүсвэр олж авах зорилгоор үнэт цаасны танилцуулгыг мэргэжлийн түвшинд бэлтгэх, түүнчлэн анхдагч зах зээл дээр борлогдоогүй үлдсэн үнэт цаасыг худалдаж авах зэрэг ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ.



Хөрөнгө оруулалтын сан (ХОС)

Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагад мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор нийтийн болон хаалттай хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгийн санг ХОС гэж нэрлэдэг. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь ХОС-тай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах СЗХ-оос тусгай зөвшөөрөл авсан байгууллага.



Зээлийн батлан даалтын сан (ЗБДС)









Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм. Гэхдээ батлан даалтын шимтгэл хураамж авах бөгөөд энэ нь сангийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зориулагддаг.



Хөдөө аж ахуйн бирж (ХААБ)

Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийг арилжих нэгдсэн төв юм. Бирж дээр борлуулагдах түүхий эд нь гарал үүсэл, чанарын гэрчилгээтэй, стандартын шаардлага хангасан байна. Бирж нь нэгдсэн мэдээллийн сангаар дамжуулан түүхий эдийг зах зээлийн үнээр борлуулах боломжийг олгодог.

Эдгээр санхүүгийн үйл ажиллагаа нь дараах тухайлсан хуулиудаар зохицуулагдсан байдаг.




-  Банкны тухай хууль /2010.01.28/
-  Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль /2002.12.12/
-  Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль /2011.10.27/
-  Даатгалын тухай хууль /2004.04.30/
-  Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2013.05.24/
-  Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль /2013.10.03/
-  Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль /2012.02.10/
-  Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль /2011.06.02/




Санхүүгийн зохицуулалт

Санхүүгийн зах зээл маш олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдгээрийн хэрэглэгчээс бүрддэг. Үүнийг зохицуулагч байгууллага гэдэг нь бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож буй санхүүгийн байгууллагуудыг хянах, үйл ажиллагааг нь найдвартай байлгах тогтолцоо, арга механизм, эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг нэмэгдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой төрийн захиргааны байгууллага юм.

Зохицуулагч байгууллагуудын хяналтын үүрэг


-  **Монголбанк:** Банкны салбар зохицуулалт, хяналт тавьж ажилладаг.
-  **Сангийн яам:** Санхүүгийн зах зээлийг зохицуулах хууль эрх зүйн актуудыг боловсруулан батлуулахаар Монгол Улсын Их Хуралд өргөн барих үүргийг хүлээнэ. Мөн санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд ерөнхий хяналтыг тавьж ажиллана.
-  **Санхүүгийн зохицуулах хороо:** Даатгал, үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг санхүүгийн байгууллагуудад хяналт тавьж ажилладаг.





Санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний өгөөж ба эрсдэл

Санхүүгийн байгууллага бүр өөрийн гэсэн онцлог бүтээгдэхүүн үйлчилгээтэй, үүнээс хамааран эрсдэл болон ашгийн түвшин ялгаатай байдаг.



Зураг 1.2. Санхүүгийн байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний өгөөж болон эрсдлийн түвшний хамаарал

Энгийн хувьцаа болон банкны хадгаламж хоёрын хувьд харьцуулалт хийж үзье. Хувьцааны хувьд тухайн компани ашигтай ажиллах тусам нэгж хувьцааны үнэ банкны санал болгож буй хадгаламжийн хүүнээс ч өндөр ашиг олох боломжтой. Гэхдээ компани ашиг багатай цаашлаад ашиггүй ажиллавал алдагдалд ч орж болзошгүй. Өөрөөр хэлбэл, хүлээж буй ашиг тодорхой бус байгаа нь эрсдэл их байгааг харуулж байна. Энэ тохиолдолд банкинд хадгалуулсан бол тогтмол хүүний орлогоор ашиг хүртэх боломжтой байсан. Дээрх зурагт харуулснаар эрсдэл их байх нь өгөөжийг их байлгах боломжтой. Иймд өөрийн хүлээх боломжтой эрсдэлийг тооцоолон бүтээгдэхүүнээ зөв сонгох нь чухал юм.



1.2. Банк, түүний бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ

Банк нь иргэдийн хадгалуулсан хөрөнгө ба өөрийн хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийг зөв зохистой удирдан ашиг олох зорилготой байгууллага юм.

Гэхдээ өмчийнх нь хэлбэрээр төрийн, хувийн, төрийн өмчийн оролцоотой банк гэж тус тус ангилдаг. Иймд Монгол Улсад банкны салбарыг хоёр шатлалт системд авч үздэг.

1.3. Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банк, Арилжааны банкуудын үндсэн үүрэг, ялгаа

Арилжааны банк нь харилцах, хадгаламж татах, зээл олгох, төлбөр тооцоо хийх үндсэн үйлчилгээ үзүүлдэг. Орчин үед харилцагчдынхаа цаг хугацаа, ажлыг хөнгөвчлөн бүтээгдэхүүн үйлчилгээгээ цахимжуулж, интернэт банк, мобайл банк, олон төрлийн карт, орлого, зарлага, мөнгөн шилжүүлэг хийдэг бэлэн мөнгөний машин зэрэг олон үйлчилгээг үзүүлдэг. Үүнээс гадна харилцагчдадаа санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөхөд анхаарч ажилладаг.



**Төрийн өмчит хуулийн
этгээд**

- Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах
- Мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх
- Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах
- Засгийн газрын санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэх

**Ашгийн төлөө төрийн
өмчит хуулийн этгээд**

- Хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх
- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах
- Өөрийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа батлан даалт гаргах
- Гадаад валют арилжаа, зээлтэй холбоотой төлбөр тооцоо

**Ашгийн төлөө хуулийн
этгээд**

- Зээл, хадгаламж
- Гадаад валют арилжаа, төлбөр тооцоо
- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах
- Үнэт зүйл, металл хадгалах
- Өөрийн нэрийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргах
- Санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах
- СЗХ-ноос зөвшөөрөлтэйгээр даатгалын зуучлал, андеррайтер, кастодиан гэх мэт үйл ажиллагаа



МОНГОЛБАНК



МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК



АРИЛЖААНЫ БАНК

Зураг 1.3. Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банк, Арилжааны банкуудын үндсэн үүрэг, ялгаа



Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ

ХАДГАЛАМЖ	ЗЭЭЛ	КАРТ	ЦАХИМ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	ГАДААД ТӨЛБӨР ТООЦОО	БУСАД САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
Харилцах Хугацаатай хадгаламж Хугацаагүй хадгаламж Хадгаламжийн сертификат	Хэрэглээний зээл Бизнесийн зээл Орон сууцны зээл Лизингийн зээл Төслийн зээл	Дотоодын карт Олон улсын карт Кредит карт АТМ буюу Бэлэн мөнгөний машины үйлчилгээ	Мобайл банк Интернэт банк И-биллинг	Гадаад гуйвуулга Вестэрн юнион Мониграм Харилцагч банкууд	Даатгалын зуучлал Кастадион Баталгаа, батлан даалт Санхүүгийн мэдээлэл, зөвлөгөө Үнэт зүйл хадгалах үйлчилгээ

Зураг 1.4. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл

Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ нь зориулалт, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн байдлаасаа хамааран маш олон төрөл байдаг.

Харилцах хадгаламж

Харилцах данс нь байгууллагын болон иргэдийн гэж байдаг. Харилцах дансанд тооцогдох хүү хадгаламжийн данстай харьцуулахад харьцангуй бага байдаг.



Хадгаламжийн дансны хувьд хугацаатай болон хугацаагүй гэж ерөнхий ангилагддаг. Хугацаатай хадгаламж нь хэдий хэр хугацаагаар хадгалах, хугацааны дундуур орлого нэмэх эсэх, хүүгээ сар бүр авах эсэх зэрэг нөхцлүүдээс хамаарч хадгаламжийн хүү ялгаатай байдаг. Хадгаламжийн сертификат нь хугацаатай хадгаламжийн төрөлд хамаарах бөгөөд хугацааны дундуур орлого нэмэх боломжгүй ч, бусдад бэлэглэх, өвлүүлэх боломжтой байдгаараа давуу талтай байдаг.



Зээл

Хэрэглээний зээлд цалингийн, тэтгэврийн, малчны, хэрэглээний лизингийн, кредит картын зээлүүдийг хамруулан ойлгоно. Бизнесийн зээлийн ангилалд эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, санхүүгийн түрээс, төслийн зээл ордог. Мөн орон сууцны зээлийн ангилалд орон сууц, хашаа байшин, амины сууц худалдан авах, засварлах, барих зээлүүдийг хамруулдаг.



Карт ба цахим бүтээгдэхүүн

Техник технологи хөгжихийн хэрээр банкны бүтээгдэхүүн үйлчилгээ улам боловсронгуй болж, банкны үйлчилгээг авахад илүү хялбар болсоор байна.

Карт нь мөнгөтэй л адил төлбөр тооцооны хэрэгсэл хэдий ч бэлэн мөнгөний сул талыг илүү найдвартай, түргэн шуурхай, боловсон байдлаараа бууруулж байдаг.

Картыг зөвхөн хугацаагүй хадгаламж болон харилцах дансандаа авах боломжтой байдаг.



Дотоодын карт: Зөвхөн Монгол Улсад ашиглах боломжтой төгрөгийн карт.



Олон улсын карт: Гадаад болон дотоодод ашиглах боломжтой гадаад валютын дансанд холбогдсон карт юм. Мөн гадаадад валютаар, дотоодод төгрөгөөр төлбөр тооцоо хийх карт бий болжээ.



ТАНЫ МЭДЛЭГТ

Картын сүлжээний төрлөөс хамааруулж Виза /VISA/, Мастер /Mastercard/, Американ экспресс /American express/, Юнион Пей /Union pay/ гэж шууд нэрлэх тохиолдол түгээмэл байдаг. АНУ-ын Виза болон Мастеркарт нь 50 гаруй жилийн түүхтэй бөгөөд 200 гаруй улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн өргөн сүлжээ юм. Харин БНХАУ-ын Юнион Пей-ийн хувьд 14 жилийн түүхтэй ба 141 оронд сүлжээгээ оруулаад байна. Мөн үүнтэй адилаар Монгол Улс ч өөрийн картын сүлжээг “Т-карт” нэртэйгээр 2012 онд гаргасан байна.

АТМ буюу бэлэн мөнгөний машин

АТМ буюу Бэлэн мөнгөний машин нь зөвхөн мөнгө авдаг биш орлого хийдэг, дансны үлдэгдлээ шалгах, мөнгөн шилжүүлэг хийдэг байхаас гадна автомашинд суурилагдсан зөөврийн хэлбэрээр ч үйлчилгээ үзүүлж байна. Бэлэн мөнгөний машин нь банкны ажилтнаас авдаг байсан үйлчилгээг өнөөдөр хүссэн үедээ өөртөө үйлчлэн авах боломжийг олгож байна.

АТМ ашиглахдаа дараах зүйлсийг анхаарна уу!

-  ПИН код /нууц дугаар/ хийхдээ бусдад харагдуулахгүйгээр нууцлах;
-  Дэлгэцийн зааварчилгаа монгол хэлний сонголттой тул зааврыг сайтар унших;
-  Гүйлгээ хийх явцдаа аль болох бусдын тусламжийг авахгүй байх;
-  АТМ-ын гүйлгээг бүрэн хийж дуустал хвлээх хэрэгтэй. Карт болон бэлэн мөнгө авах зааварчилгаа гарснаас хойш үйлдэл хийхгүй 30 секунд болвол АТМ картыг буцааж татах тохиргоотой байдаг.
-  Мөн картын нууц дугаараа олон дахин буруу хийхэд АТМ картыг залгидаг.
-  Нэгэнт картаа залгиулсан бол АТМ дээрх банкны холбогдох утас руу холбогдож картаа буцаан авна.
-  Картаар үйлчлүүлж байх үед бусдын халдлагад өртөх нөхцөл байдалд орвол пин кодоо урвуулан хийснээр танд яаралтай тусламж ирэх болно.



Мобайл банк

Орчин үед арилжааны банкууд гар утсанд тохирсон мобайл банкны цэстэй болжээ. Банкин дээр нэг удаа очиж гэрээ байгуулан гар утсандаа мобайл банкны цэс суулгана. Ингэснээр дансны үлдэгдэл болон хуулгаа шалгах, банк дотроо болон өөр банк хооронд мөнгө шилжүүлэх, зээлээ төлөх, гар утас болон байрны төлбөр төлөх, валютын ханшийн мэдээлэл авах зэрэг банкны үйлчилгээг авах боломж бүрдэнэ.

Интернэт банк

Банкны үйлчилгээ улам л амар хялбар болж байна. Интернэтийн сүлжээтэй л бол байгаа аль ч газраасаа банкны үйлчилгээг авах нөхцөл бүрдсэн. Энэ бол интернэт банк бөгөөд харилцдаг банкиндаа нэг удаа хандаснаар ашиглах эрхээ нээлгэнэ. Мөн гар утсандаа банкуудын интернэт банкны аппликейшн/цэсийг суулгаад эсвэл банкуудын мэдээллийн цахим хуудас руу орж үйлчилгээг авна.

Ихэнх арилжааны банкны интернэт банкаар дамжуулан дараах үйлчилгээг өөрөө өөртөө үзүүлэх боломжтой. Үүнд:

Хүснэгт 1.2. Интернэт банкаар хийх үйлчилгээ

Дансны үлдэгдэл, хуулга харах, хянах;	Өөрийн дансаа удирдах, үйлчилгээнд ашиглах дансуудаа нэмж, хасах;
Дотоод шилжүүлгийн гүйлгээ хийх (Банк дотроо болон банк хооронд);	Цахим үйлчилгээнд бүртгүүлэх
Гадаад шилжүүлгийн гүйлгээ хийх;	Зээлийн төлбөр төлөх;
Валютын ханшийн мэдээлэл авах;	Гар утас, байрны төлбөрөө төлөх;
Данс нээх;	Татварын мэдээлэл харах, төлөх
Хадгаламжийн хугацаагаа сунгах;	Хадгаламж барьцаалсан зээл авах /Зарим банкинд энэ үйлчилгээ амжилттай хэрэгжиж байна/;
Арилжааны хэлцэл хийх;	Хувийн санхүүгээ хөтлөх, хянах гэх мэт.
Өөрийн мэдээллийг засах, өөрчлөх;	



Хүснэгт 1.3. Мобайл банк, интернэт банкны гол ялгаа

Мобайл банк	Интернэт банк
Үүрэн телефоны сүлжээ ашигладаг	Интернэтийн сүлжээ ашигладаг
Цөөн төрлийн гүйлгээ хийдэг	Олон төрлийн гүйлгээ хийдэг

И-биллингийн үйлчилгээ

Сар бүр гардаг хэрэглээний төлбөрөө өөрийн данснаасаа шууд суутгуулах хүсэлтийг банкинд нэг удаа очиж гаргаад банкинд байнга очихгүйгээр төлбөрөө цаг тухайд нь төлж байх боломжийг энэхүү үйлчилгээ олгодог. Өөрөөр хэлбэл гэрээ байгуулсны үндсэн дээр таны өмнөөс хэрэглээний төлбөрийг тань банк шилжүүлдэг үйлчилгээ юм. Харин та тухайн гэрээнд тусгасан дансаа өөрийн тогтмол орлого ордог данстайгаа холбуулах хэрэгтэй.

Гадаад төлбөр тооцоо

Монголын банкууд нь гадаадын банкуудтай харилцан хамтын ажиллагаа тогтоосны үндсэн дээр Олон улсын банк хоорондын сүлжээ /SWIFT/-ээр дамжуулан гадаад руу мөнгөн шилжүүлэг хийдэг.

Дэлхийн хамгийн олон оронд салбартай Вестэрн Юнионы /Western Union/ сүлжээгээр дамжуулан бэлэн мөнгөний гуйвуулга хийх шуурхай үйлчилгээ үзүүлдэг.

Мөн Мониграм /Moneygram/-ын сүлжээгээр дамжуулан гадаад шилжүүлэг хийх боломжтой. Энэхүү гадаад шуурхай шилжүүлэг нь улс орны хамрах хүрээ, үйлчилгээний шимтгэл хураамжаараа бага зэрэг ялгаатай байдаг.





Даатгалын зуучлалын үйлчилгээ

Арилжааны банк нь Банкны тухай хууль болон “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай” хуулийн хүрээнд Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-оос авсны үндсэн дээр даатгалын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон. Өөрөөр хэлбэл, банкнаас даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломж бүрдэж байна.



1.3. Банкнаас бусад санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ

Хүснэгт 1.4. Санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ

 ДААТГАЛ	 ҮЦК	 ХОС	 ХААБ
<p>Ердийн даатгал</p> <ul style="list-style-type: none"> - Гэнэтийн ослын даатгал - Эд хөрөнгийн даатгал - Санхүүгийн даатгал <p>Урт хугацааны даатгал</p> <ul style="list-style-type: none"> - Амь насны даатгал - Тэтгэврийн даатгал - Эрүүл мэндийн даатгал 	<ul style="list-style-type: none"> - Компанийн хувьцаа, бонд худалдах, худалдан авах үйлчилгээ - Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ - Хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл өгөх үйлчилгээ - Хөрөнгийн зах зээл, хувьцаа, бонд 	<p>Хөрөнгөө өсгөн нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн компанид шилжүүлэн хөрөнгө оруулалт хийх</p>	<p>Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг ил тод зах зээлийн ханшаар худалдах, худалдан авах боломжтой.</p>
<p>ББСБ</p>	<p>ХЗХ</p>	<p>ЗБДС</p>	
<ul style="list-style-type: none"> - Зээл - Валют арилжаа - Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх - Итгэлцлийн үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> - Зөвхөн ХЗХ-ны гишүүдэд - Зээл - Хадгаламж 	<p>Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад дутагдаж буй барьцаа хөрөнгөд батлан даалт гаргах үйлчилгээ</p>	




Санхүүгийн зах зээл дээрх эдгээр олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнээс өөрийн эрэлт хэрэгцээнд тохирсон сонголтыг хийхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, давуу, сул талуудыг харьцуулж судалсны үндсэн дээр санхүүгийн шийдвэрээ гаргаж сурах нь чухал юм.

Жишээ: Телевизор үзэж буй Тэмүүлэнгийн гэр бүл Засгийн газрын бонд арилжаалагдсан талаар мэдээллийг үзээд дараах яриаг өрнүүлэв.

Сүүлийн үед
Засгийн газрын
бондын талаар их яригдах
боллоо. Хувь хүн худалдан
авч болдог юм болов уу? Энэ
нь хуримтлалаа өсгөх нэг
арга биш үү?

Харин тийм. Иргэд
арилжаанд оролцох
боломжтой гэж сонссон.
Гэхдээ яаж хамрагдах
талаар нарийн журмыг
судалж үзье.



Тэмүүлэн судалж үзээд дараах мэдээллүүдийг цуглуулжээ. Засгийн газрын бондыг иргэн, аж ахуйн нэгжүүд аль аль нь худалдан авах боломжтой бөгөөд нэг бүрийн нэрлэсэн үнэ нь 100000 төгрөг, тогтсон хугацаанд хүү төлдөг Засгийн газрын өрийн бичиг. Үүнийг авахын тулд дараах схемийн дагуу Хөрөнгийн биржэд бүртгэлтэй брокер, дилерийн компанид хандан өөрийн нэр дээр үнэт цаасны данс нээлгэн, захиалга өгч, төлбөрөө арилжааны банкаар дамжуулан төлдөг. Засгийн газрын бонд худалдан авах үйл явцыг дараах зургаар харуулав.



Зураг 1.5. Засгийн газрын бонд худалдан авах үйл явц

Засгийн газрын бонд нь дараах хэд хэдэн давуу талтай.

- 🏠 Засгийн газар нь зээлдэгч учраас тухайн улсдаа хамгийн эрсдэлгүй хөрөнгө оруулалтын нэгд тооцогддог.
- 🏠 Үнэт цаасны төлбөр болон хүү нь иргэд болон аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгддөг.
- 🏠 Зах зээлийн зарчмаар хүүний өгөөж нь тогтоогддог учраас өгөөж өндөр байх боломжтой.
- 🏠 Худалдан авагч нь бэлэн мөнгөний хэрэгцээ үүссэн үедээ бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах боломжтой.

Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсан дээр илүү дэлгэрэнгүй мэдээлэл байдаг.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ




1.1. Хөрөнгө оруулалтын зорилго, төрөл

Хөрөнгө оруулалт гэдэг нь ашиг олох, хөрөнгөө өсгөх зорилгоор тодорхой нэг хөрөнгөд мөнгөө байршуулахыг хэлнэ. Хөрөнгө оруулагчид зорилгодоо хүрч хөрөнгийнхөө үнэ цэнийг өсгөж, ашиг олох боломж байдаг хэдий ч хөрөнгө оруулалт нь ашиггүй болж, хөрөнгө нь үнэ цэнээ алдах тохиолдол ч цөөнгүй бий.

Юунд хөрөнгө оруулж болох вэ?

Хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө, банкны хадгаламж зэргээр хөрөнгө оруулалтын олон хувилбар бий. Эдгээр нь бүгд өөр өөрсдийн давуу болон сул талтай.



Зураг 1. Хөрөнгө оруулалтын төрөл, хөрвөх чадвар



Хөрөнгө оруулалт хийхэд хэр их мөнгө хэрэгтэй вэ?

Хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай хөрөнгийн доод хэмжээ гэж байхгүй. Жишээлбэл, та 5000 төгрөгтэй бол 100 төгрөгийн үнэтэй 50 хувьцаа авах боломжтой.

Хүснэгт 1. Зарим нэг хувьцааны үнэ (2022.08.22-ны байдлаар)

				
Код	MNDL	ADB	HBO	LEND
Нэр	Мандал Даатгал ХК	Ард кредит ББСБ ХК	Хай Би Ойл ХК	ЛэндМН ББСБ ХК
Үнэ	93 төгрөг	102 төгрөг	41 төгрөг	33 төгрөг

ТАНЫ СОНОРТ:







Үнэт цаас, хувьцааны талаар ойлголтгүй байсан нь олон хүний хувьд цэнхэр, ягаан тасалбараа будаа, гурил, эсгий гутлаар солиход хүргэжээ. Дахиад тэдний алдааг давтах хэрэггүй. 1992 онд Монгол Улсын 1.1 сая иргэнд 475 улсын үйлдвэрийн газрыг цэнхэр, ягаан тасалбараар эн тэнцүүхэн хувьчилж өгсөн. Гэтэл энэ хөрөнгө Монгол Улсын нийт хүн амын 1 хувьд төвлөрч байна гэвэл та итгэх үү? Үнэндээ бол тийм.

Хувьцааны ашиг тусыг мэддэг хүмүүс хувьцаа цуглуулж, харин мэддэггүй нь сольж, зарж байсан. Ихэнх хүмүүс үнэт цаасны зах зээл гэж юу болох, хувьцаа ямар ашиг тустай болох талаар ойлголтгүйгээсээ болж хөрөнгө оруулалтын эрхийн бичиг болох цэнхэр, ягаан тасалбараа ашиглаж чадаагүй. Цаашид Эрдэнэс таван толгойн хувьчлал цаасан дээрээс бирж рүү шилжих үед иргэн бүр үнэт цаасны зах зээл, хувьцааны талаар тодорхой ойлголттой болох нь зүйн хэрэг юм.





Уламжлалт хөрөнгө оруулалттай харьцуулахад уламжлалт бус хөрөнгө оруулалт нь дараах шинж чанартай. Үүнд:

-  Хувьцаа, бонд зэрэг уламжлалт хөрөнгө оруулалтаас хамаарах хамаарал багатай байна.
-  Энэ төрлийн хөрөнгө оруулалтын зах зээл дэх өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход хэцүү
-  Хөрвөх чадвар харьцангуй муутай байдаг.
-  Худалдан авах, худалдах арилжааны зардал харьцангуй ихтэй байдаг.
-  Эрсдэл болон өгөөжийг тооцоход хүндрэлтэй байдаг.
-  Хөрөнгө оруулахаасаа өмнө нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай.

Хөрөнгө оруулалтын олон сонголтуудын нэг талд хамгийн аюулгүй, найдвартай хөрөнгө оруулалт болох Засгийн газрын бонд, хадгаламжийн сертификат, хадгаламжийн данс, нэр хүнд бүхий компанийн бонд, хувьцаа зэрэг багтах бол нөгөө талд, харьцангуй богино хугацаанд их хэмжээний ашиг олох сонирхлыг төрүүлдэг, эрсдэл ихтэй хөрөнгө оруулалтууд багтдаг. Эрсдэл ихтэй хөрөнгө оруулалт их хэмжээний ашиг амладаг ч амжилт олох нь бага бөгөөд хөрөнгө оруулагч хөрөнгийнхөө ихэнх хэсгийг, тэр ч байтугай бүгдийг алдаж болох магадлалтай. Эрсдэл өндөртэй хувьцаа, бонд, зарим төрлийн үл хөдлөх хөрөнгүүд, үнэт чулуу, үнэт металл, цуглуулга, бараа таваар, опцион зэрэг нь хөрөнгө оруулалтын энэ төрөлд хамаардаг.

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын хэлбэр (өгөөж, эрсдэл, хөрвөх чадвар)

	Хөрөнгө оруулалтын хэлбэрүүд	Аюулгүй байдал	Эрсдэл	Ашиг/Өгөөж	Өсөлт	Хөрвөх чадвар
Уламжлалт хөрөнгө оруулалт	Энгийн хувьцаа	Дунд	Дунд	Дунд	Их	Дунд
	Давуу эрхтэй хувьцаа	Дунд	Дунд	Их	Дунд	Дунд
	Компанийн бонд	Дунд	Дунд	Их	Бага	Дунд
	Засгийн газрын бонд	Өндөр	Бага	Бага	Бага	Сайн
	Хамтын сан	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд
	Үл хөдлөх хөрөнгө	Дунд	Дунд	Дунд	Дунд	Муу



	Хөрөнгө оруулалтын хэлбэрүүд	Аюулгүй байдал	Эрсдэл	Ашиг/Өгөөж	Өсөлт	Хөрвөх чадвар
Уламжлалт бус хөрөнгө оруулалт	Опцион	Бага	Их	тодорхойгүй	Бага	Дунд
	Таваар	Бага	Их	тодорхойгүй	Бага	Дунд
	Деривативууд	Бага	Их	тодорхойгүй	Бага	Дунд
	Үнэт металл, үнэт эдлэл	Бага	Их	тодорхойгүй	Бага	Муу

Хүснэгтээс харахад уламжлалт хөрөнгө оруулалтын эрсдэл харьцангуй бага байх бол уламжлалт бус хөрөнгө оруулалт нь эрсдэл ихтэй байна. Эрсдлийн хэмжээнээс хамаарч өгөөжийн хэмжээ тодорхойлогдож байна.

ЭРСДЭЛ БА ӨГӨӨЖ



Эрсдэлгүй хөрөнгө оруулалт:

Богино, дунд хугацаанд ашиг болон эрсдэл харьцангуй бага байх хөрөнгө оруулалт

Эрсдэлтэй хөрөнгө оруулалт:

Богино хугацаанд их хэмжээний ашиг олох сонирхлыг төрүүлдэг, өндөр эрсдэл дагуулдаг хөрөнгө оруулалт

Эрсдэл өгөөж хоёр зэрэг хамааралтай

Зураг 2. Эрсдэл өгөөжийн хамаарал




1.2. Хөрөнгө оруулалтын эрсдэл ба өгөөж

Хөрөнгө оруулагч бүрийн эцсийн зорилго нь ашиг олох явдал байдаг. Зарим хүмүүс өндөр эрсдэлтэйгээр их ашиг олохыг хүсдэг бол зарим нь эрсдэл багатайгаар тогтмол ашиг олохыг эрмэлздэг. Иймд юунд хөрөнгө оруулахаа шийдэхдээ хөрөнгө оруулалтын зорилго, эрсдэл даах чадварт нийцүүлэх хэрэгтэй.

Эрсдэл даах чадвар нь хувь хүний онцлогоос шалтгаалан хүн бүрт өөр өөр байдаг. Тухайн хүний нас, санхүүгийн чадвар, эрхэлдэг ажил, одоогийн орлогын хэмжээ, цаашид орлого олох чадвар зэрэг олон хүчин зүйл хөрөнгө оруулалтын эрсдэл даах чадварыг тодорхойлдог. Жишээлбэл, дөнгөж ажлын гараагаа эхэлж буй өсөх ирээдүйтэй залуу хүн эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийхэд алдагдал хүлээсэн ч цаашид хөрөнгөө нөхөх, өсгөх хангалттай хугацаа бий. Тийм учраас эрсдэл даах чадвар өндөр байна.

Орлогын олон эх үүсвэртэй хүн эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийгээд хөрөнгийн үнэ цэнээ алдсан ч бусад хөрөнгөөрөө амьдралаа авч явах боломжтой тул эрсдэл даах чадвар бас өндөр байна. Харин орлогын ганц эх үүсвэртэй, хурааж хуримтлуулсан хөрөнгөөрөө амьдарч буй хүмүүс бүх хөрөнгөө эрсдэлтэй хөрөнгөд байршуулах нь зөв шийдвэр биш. Учир нь хөрөнгийн үнэ цэнэ буурах тусам тухайн хүний ирээдүйд амьдралаа авч явах орлого нь багасаж байгаа учраас хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хувилбарт дийлэнх хөрөнгөө байршуулах нь зүйтэй.




**Хөрөнгө оруулалтын алтан дүрэм:
Нэг өндгөө бүх өндгөө битгий хий**

Зураг 3. Хөрөнгө оруулагчийн хэв шинжээс хамаарсан багц бүрдүүлэлтийн жишээ



Ихэвчлэн тухайн хүний нас залуу, хөрөнгө бэл их, орлогын олон эх үүсвэртэй, орлого нь тогтмол, санхүүгийн хэрэгцээ /тухайлбал, хүүхдүүдийн сургууль цэцэрлэгийн төлбөр гэх мэт/ бага байх тусмаа эрсдэл даах чадвар өндөр байна. Эсрэгээр нас өндөр, хөрөнгө хуримтлал багатай, санхүүгийн хэрэгцээ ихтэй, тогтмол орлого бага байх тусмаа эрсдэл даах чадвар бага буюу аль болох болгоомжтой хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй юм.



Зураг 4. Хөрөнгө оруулалтын төрөл, тэдгээрийн эрсдэл ба өгөөжийн ерөнхий түвшин

Гэхдээ та хувьцаа, бонд, хадгаламж, үл хөдлөх хөрөнгө зэргээр өөр, олон төрлийн хөрөнгүүдэд хөрөнгөө тараан байршуулах замаар хөрөнгө оруулалтын эрсдлийг бууруулж болно. Хөрөнгө оруулалтын нэг алтан дүрэм бол “бүх өндгөө нэг сагсанд битгий хий” бөгөөд хөрөнгөө тараан байршуулах нь эрсдлээс сэргийлэх хамгийн зөв алхам юм.



Хөрөнгөө тараан байршуулах гэдэг нь бүх мөнгөөрөө нэг төрлийн хөрөнгө худалдаж авахгүйгээр, олон төрлийн хөрөнгөд мөнгөө хувааж хөрөнгө оруулахыг хэлдэг. Жишээлбэл, та хувьцаа худалдаж авах гэж байгаа бол бүх мөнгөөрөө нэг компанийн хувьцаа авснаас өөр өөр салбарт үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн компанийн хувьцаа худалдаж авахыг тараан байршуулалт гэдэг. Ингэснээр нэг компанийн хувьцааны үнэ буурах үед нөгөө компанийнх өсөх байдлаар таны нийт хөрөнгө оруулалтын үнэ цэнэ огцом унах эрсдэл буурна.

Хөрөнгө оруулагчид ийнхүү хөрөнгө оруулалтын эрсдлээ тараан байршуулж, өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор хэд хэдэн төрлийн хөрөнгөөс бүрдэх **хөрөнгө оруулалтын багц** үүсгэж болно. Багцад орох хөрөнгө оруулалтын төрөл болон хэмжээг сонгохдоо хувь хүний эрсдэл хүлээх чадвар, хүсэж буй өгөөжийн түвшин, хөрөнгө оруулалтын хугацаа зэрэг хүчин зүйлийг харгалзан дараах зурагт үзүүлсэн байдлаар үүсгэж болно.

Хөрөнгө оруулах компани сонгохдоо хамгийн түрүүнд тус компанийн үйл ажиллагаа явуулж буй салбар, зах зээл өсөж томрох боломжтой эсэх, тухайн компанийн өрсөлдөгчид нь зах зээлд хэр хүчтэй байр суурьтай компаниуд байдаг, тухайн компани өсөж томрох боломж байгаа эсэх, компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь ирээдүйд хэр их эрэлттэй байх, улмаар орлогоо нэмэгдүүлэх боломж байгаа эсэх, компанийн удирдлагууд нь хэр туршлагатай, засаглал сайтай, зах зээлээ мэддэг хүмүүс байгаа, одоогийн орлого, ашгийн түвшин ямар байгаа зэрэг суурь хүчин зүйлүүдийг мэдэж судлахаас эхлэх нь зүйтэй юм. Мэргэжлийн бус хүний зөвлөгөө, ам дамжсан яриан дээр үндэслэж хөрөнгө оруулах нь мөрийтэй тоглохтой адил гэдгийг анхаарч болгоомжлох нь зүйтэй.

Дээр дурдсан хүчин зүйлүүдийг судлахаас гадна, Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан компаниудад хандан зөвлөгөө авч үйлчлүүлэх боломжтой билээ.




1.3. Хувьцааны хөрөнгө оруулалт



Хувьцаа нь компанийн тодорхой хэсгийг эзэмших эрх юм. Жишээлбэл, та нийт 10,000 ширхэг хувьцаатай компанийн 100 ширхэг хувьцааг эзэмшдэг гэвэл тэр компанийн 1%-н эзэн гэсэн үг.

Хувьцаанд хөрөнгө оруулах нь дараах давуу талуудтай. Үүнд:

 Хувьцааны үнэ цэнэ өсөх.

Таны авсан хувьцаа анх худалдаж авсан үнээсээ өсөх боломжтой.

 Ногдол ашиг хүртэх.


Ногдол ашиг гэдэг нь компани тухайн жилд олсон ашгаа хувьцаа эзэмшигчиддээ тараахыг хэлдэг. Компани ашгаа тараахын оронд шинэ тоног төхөөрөмж худалдаж авах, үйлдвэрлэлээ өргөтгөх зэргээр дотооддоо ашиглаж болох тул компани жил бүр ногдол ашиг тараахгүй байж болно.

 Хөрвөх чадвар сайн.

Танд бэлэн мөнгө хэрэгтэй болсон үед хувьцаагаа худалдаад түргэн бэлэн мөнгөтэй болох боломжтой ч зарим компанийн хувьцаа түргэн, зарим нь удаан зарагддаг гэдгийг анхаараарай.

 Саналын эрх.

Та эзэмшиж буй хувьцааныхаа тоотой тэнцүү хэмжээгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгч, Төлөөлөн Удирдах Зөвлөл /удирдлагад хяналт тавих зөвлөл/-ийг сонгох эрхтэй.



Зураг 5. Хувьцааны үр өгөөж

ТАНЫ МЭДЛЭГТ:

Хөгжилтэй орнуудын хүн амын 45-80 % нь хувьцааны талаар мэдлэгтэй. Харин манай улсын хувьд хүн амын 12 орчим хувь нь л хувьцааны талаар ойлголттой байна .

Хувьцаанд хөрөнгө оруулах нь дараах сул талуудтай. Үүнд:

Хөрөнгө үнэ цэнээ алдах

Хувьцааны үнэ цэнэ өсөж буурах байнгын хэлбэлзэлтэй байдаг. Хэрэв компанийн үйл ажиллагаа муудвал, компанийн хувьцааны үнэ цэнэ буурна. Хамгийн муугаар бодоход, компани дампуурвал тухайн компанийн бусдад төлөх өр төлбөрийг бүрэн төлсний дараа үлдсэн хөрөнгийг хувьцаа эзэмшигчид хувааж авдаг. Тиймээс анх хийсэн хөрөнгө оруулалт бүрэн үнэгүйдэх ч тохиолдол гарч болно.

Удаан хугацааны хүлээлт

Ихэнх хувьцаа удаан хугацаанд өгөөжөө өгдөг тул ашиг хүртэхийн тулд заримдаа хувьцаагаа хэдэн жил хадгалах хэрэгтэй болдог. Иргэд ногдол ашгаас мөнгө хүртэх сонирхолтой байдаг ч хэрвээ компани алдагдалтай ажиллавал ногдол ашиг тараахгүй нь тодорхой. Нөгөөтэйгүүр компани ашигтай ажилласан ч "ногдол ашгийн бодлого"-оор олсон ашгаа дахин хөрөнгө оруулалт хийх боломжтой. Энэ үед ногдол ашиг хүртэхгүй хэдий ч, хөрөнгө оруулалтаар дамжиж компанийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний сав баглаа, маркетинг зэрэг нь сайжирснаар хувьцааны үнийн өсөлт бий болж зарах замаар анх авсан үнийн зөрүүнээс ашиг олох боломжтой.

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлгүй этгээдийн зөвлөгөө, ам дамжсан яриан дээр үндэслэж хөрөнгө оруулах нь өндөр эрсдэлтэйг анхаараарай.



ТАНЫ МЭДЛЭГТ:

“Сүү” ХК-ийн хувьцаа 2008 оны 11-р сарын 27-ны өдөр 1000 төгрөгийн үнэтэй байсан бол 2016 оны 06-р сарын 10-ны өдөр 145,000 төгрөгөөр үнэлэгдэж 8 жилийн хугацаанд 145 дахин өссөн байна. Уг хувьцааны жил тутмын өгөөж нь ойролцоогоор 86 орчим хувь байсан байна. Энэ нь банкны хадгаламжийн хүүнээс даруй 5-6 дахин их аж. “Сүү” ХК 2008 оноос үйлдвэрийн шинэ шугам ашиглалтад оруулж хүчин чадал, бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмснээр хувьцааных нь ханш ийнхүү өссөн. Нөгөөтэйгүүр, хувьцааны үнэ хэт өндөр болох нь тухайн хувьцааг худалдаж авах идэвхийг бууруулдаг. Тиймээс хувьцааны арилжааны идэвхийг нэмэгдүүлэхийн тулд хувьцааг хуваах арга хэмжээ авах боломжтой ба “Сүү” ХК 2016 онд 145,000 төгрөг болоод байсан нэгж хувьцааг 1000 хувааж, нэг хувьцааны үнийг 145 төгрөг болгосон. Энэ үед хувьцаа эзэмшигчдийн багцад тооны өөрчлөлт орж байгаа ч, чанарын өөрчлөлт гарахгүй юм. Үүний дараа 145 төгрөг болсон хувьцааны арилжааны идэвх нэмэгдэж, 2020 онд 210 төгрөг болж үргэлжлэн өссөн. Хувьцаагаар хэрхэн мөнгө хийж болохыг энэхүү жишээ харуулж байна. Гэхдээ энд анхааруулж тэмдэглэхэд хувьцаатай болмогц мөнгө асгарах юм шиг ойлгож болохгүй. Ашиг их бол эрсдэл их байдаг ба хувьцааны үнэ тогтмол өсөхгүй, зарим үед буурч байдаг.

"СҮҮ" ХК-ийн хувьцаа





Энгийн хувьцаа

Зах зээл дээр нийтэд санал болгож байгаа, саналын эрхтэй хувьцааг энгийн хувьцаа гэнэ. Хувьцаа бол компанийн дүрмийн сан буюу өөрийн хөрөнгийг бүрдүүлдэг санхүүгийн хэрэгсэл юм. Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа бусдад худалдах боломжтой байдаг. Хувьцааг худалдах үнэ нь худалдан авагчийн хувьцаанд төлөхөд бэлэн байгаа үнээр тодорхойлогддог. Компанийн ирээдүйн борлуулалтын орлого, ашиг, өргөжилт, эсвэл нэгдэлт, бусад хүчин зүйлс нь хувьцааны үнийг өсгөх эсвэл бууруулах шалтгаан болно.

Ногдол ашгийг компанийн цэвэр ашгаас төлдөг бөгөөд компанийн төлөөлөн удирдах зөвлөл(ТУЗ)-өөс хуваарилах ногдол ашгийн хэмжээг баталдаг. Ногдол ашиг бол хувьцаа эзэмшигчдийн хувьд оруулсан хөрөнгө оруулалтаасаа хүртэж буй өгөөж юм.

Хүснэгт 3. Энгийн болон давуу эрхийн хувьцааны ялгаа

Энгийн хувьцаа	Давуу эрхийн хувьцаа
Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхтэй.	Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхгүй.
Ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд авна.	Тогтмол хэмжээний ногдол ашиг олгоно.
Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг тараасны дараагийн ээлжинд ногдол ашгаа авна.	Эхний ээлжинд ногдол ашиг авна.
Ногдол ашиг олгоогүй үед компани нөхөн олгох үүрэг хүлээхгүй.	Олгоогүй ногдол ашиг компанийн хувьд өр хэлбэрээр бүртгэгдэх учир заавал нөхөн олгоно.
Компани дампуурснаас хөрөнгө хуваарилах тохиолдолд зээлдүүлэгчид, давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн дараа авна.	Компани дампуурснаас хөрөнгө хуваарилах тохиолдолд зээлдүүлэгчийн дараа, энгийн хувьцаа эзэмшигчийн өмнө хөрөнгөө авна.
Компанийн үйл ажиллагааны ашиг алдагдал нь ногдол ашиг авах эсэхэд шууд нөлөөлнө.	Компанийн үйл ажиллагааны ашиг алдагдал бараг нөлөөлдөггүй. Учир нь ногдол ашгаа тогтмол авах нөхцөлтэй.
Хувьцааны ханшийн өсөлт бууралт хувьцаа эзэмшигчдийн орлогод шууд нөлөөлнө.	Энгийн хувьцааны ханшийн өөрчлөлт давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд нөлөөлөхгүй.



Давуу эрхийн хувьцаа

Та энгийн хувьцаа худалдан авахын оронд давуу эрхийн хувьцаа худалдан авч болно. Давуу эрхийн хувьцаа бол энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос өмнө ногдол ашиг хүртэх эрхийг эзэмшигчдээ олгодог хувьцааны нэг төрөл юм. Энэ нь хөрөнгө оруулагчдын давуу эрхийн хувьцааг сонирхдог нэг чухал зүйл.

Давуу эрхийн хувьцаа нь энгийн хувьцаа (хувьцаа эзэмшигчийн хувьд өмчлөгч) болон компанийн бонд (бонд эзэмшигчийн хувьд зээлдүүлэгч)-ын хоорондох хөрөнгө оруулалтыг төлөөлдөг учраас "холимог шинжтэй хөрөнгө оруулалт" гэж нэрлэдэг. Компанийн бондтой харьцуулахад давуу эрхийн хувьцааны өгөөж бондын өгөөжөөс ихэвчлэн бага байдаг бол энгийн хувьцаатай харьцуулахад илүү найдвартай хөрөнгө оруулалт болдог. Учир нь энгийн хувьцааны хөрөнгө оруулалтаас илүү тогтвортой орлого санал болгодог. Мөн ногдол ашгийн орлогод татварын хөнгөлөлт эдлэх боломжтой учраас компаниуд давуу эрхийн хувьцаа худалдан авдаг байна.

ТАНЫ МЭДЛЭГТ:

УИХ-ын 2010 оны 39-р тогтоол, 2012 оны 18-р тогтоол болон Засгийн газрын 2011 оны 3-р сарын 31-ний өдрийн 98-р тогтоол, 2012 оны 4-р сарын 11-ний өдрийн 116-р тогтоолын дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 20 хүртэлх хувийг 2012 оны 4-р сарын 11-нээс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр болсон. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын 2.7 сая иргэн Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаанаас тус бүр 1072 ширхгийг эзэмших эрхтэй.

Таны эзэмшиж буй "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 1072 ширхэг хувьцаа нь энгийн хувьцаа юм. Харин "Хүний хөгжлийн сангийн тухай" хуульд зааснаар иргэн бүр "Эрдэнэс МГЛ" компанийн нэг ширхэг давуу эрхийн хувьцааг эзэмшинэ. Энэхүү үйл ажиллагааг Монгол Улсын засгийн газрын 2012 оны 06-р сарын 25-ны өдрийн 218 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Уг тогтоолоор хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй иргэн бүр нэг ширхэг давуу эрхийн хувьцааг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй. Харин давуу эрхийн хувьцааг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах, өв залгамжлах нь хуулиар хориотой. Мөн тухайн хүн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмших эрх нь дуусгавар болно.



Та аливаа хувьцаанд хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө хувьцааны арилжааны мэдээлэлтэй танилцаж, хувьцаатай холбоотой зохих ёсны судалгааг хийвэл зохино.

Хүснэгт 4. Хувьцааны арилжааны дэлгэрэнгүй мэдээ

Симбол	Үнэт цаасны нэр	Ширхэг	Үнийн дүн	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Зах зээлийн үнэлгээ	Авах	Зарах	Арилжаа
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
BODI	Бодь Даатгал ХК	3,020	395,620.00	131.00	131.00	890.00	131.00	29,904,084,998.00	129.00	131.00	Энгийн

Эх сурвалж. Монголын хөрөнгийн бирж, 2022 оны 8-р сарын 19-ний өдрийн арилжаа

Тайлбар:

1. МХБ-д бүртгэлтэй Бодь Даатгал ХК-ийн хувьцааны латин үсгээр илэрхийлэгдсэн код;
2. Үнэт цаас гаргаж арилжаалсан компанийн нэр;
3. Тухайн өдөр арилжаалагдсан хувьцааны тоо;
4. Арилжаалагдсан хувьцааны тоог нэгж хувьцааны хаалтын ханшаар үржүүлсэн дүн буюу тухайн өдөр арилжаалагдсан хувьцааны нийт үнийн дүн;
5. Тухайн өдрийн арилжааны нээлтийн ханш. Энэхүү ханш арилжааны өдөр бүр Улаанбаатарын цагаар 09:40-10:00 цагийн хооронд тогтдог;
6. Тухайн өдрийн арилжааны дээд ханш. Өөрөөр хэлбэл, тухайн өдрийн нэгж хувьцааны хамгийн өндөр үнэтэй захиалга 131.00 төгрөгөөр хэрэгжсэн;
7. Тухайн өдрийн арилжааны доод ханш. Өөрөөр хэлбэл, тухайн өдрийн нэгж хувьцааны хамгийн бага үнэтэй захиалга 131.00 төгрөгөөр хэрэгжсэн;
8. Тухайн өдрийн арилжааны хаалтын ханш. Энэхүү ханш арилжааны өдөр бүр Улаанбаатарын цагаар 13:00-13:05 цагийн хооронд тогтдог;
9. Бүртгэлтэй хувьцааны тоог нэгж хувьцааны хаалтын ханшаар үржүүлсэн дүн буюу 2022 оны 8-р сарын 22-ний өдрийн байдлаарх Бодь Даатгал ХК-ийн үнэлгээ;
10. Тухайн өдрийн арилжаагаар худалдан авахаар захиалга өгсөн нэгж хувьцааны үнэ;
11. Тухайн өдрийн арилжаагаар худалдахаар захиалга өгсөн нэгж хувьцааны үнэ;
12. Хөрөнгийн бирж дээрх арилжаа энгийн болон багцын гэсэн 2 төрөлтэй. Хувьцааны арилжаа ердийн горимын дагуу явагдсаныг илэрхийлж буй энгийн арилжаа.



Үнэт цаасанд хэчнээн хэмжээний хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахдаа дараах төрлийн мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглаж болно. Үүнд:

Мэдээлэл хаанаас авах вэ?

1. Интернет

Монголын хөрөнгийн биржийн сайт (www.mse.mn)
Монголын үнэт цаасны биржийн сайт (www.msx.mn)

Үнэт цаасны үнэ ханш, арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл болон үнэт цаас гаргагчтай холбоотой мэдээллийг

2. Сонин хэвлэл, мэдээллийн хөтөлбөр

Өдөр тутмын сонин хэвлэл, эдийн засаг, санхүүгийн чиглэлийн сэтгүүлүүд болон санхүүгийн нэвтрүүлэг

Зах зээлийн төлөв байдал, салбарын мэдээлэл, улс төр, нийгмийн байдлын талаар мэдээллийг

3. Засгийн газрын тайлан хэвлэл

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны тайлан

Хөрөнгө оруулагчид шаардагдах мэдээллийг

4. Компанийн тайлан

Хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн цахим хуудсанд нийтлэгдсэн тайлан

Компанийн ашиг, орлого, хөрөнгө, өр төлбөр, бүтээгдэхүүн, үйлчилгээ гэх мэт.

Мэдээлэл бол амжилттай хөрөнгө оруулалтын хоёр дахь хагас

Зураг 6. Үнэт цаасны талаарх мэдээллийн эх сурвалжууд

ТАНЫ МЭДЛЭГТ:

Үнэт цаас, хувьцааны талаар ойлголтгүй байсан нь олон хүний хувьд цэнхэр, ягаан тасалбараа будаа, гурил, эсгий гутлаар солиход хүргэжээ. Дахиад тэдний алдааг давтах хэрэггүй. 1992 онд Монгол Улсын 1.1 сая иргэнд 475 улсын үйлдвэрийн газрыг цэнхэр, ягаан тасалбараар эн тэнцүүхэн хувьчилж өгсөн. Гэтэл энэ хөрөнгө Монгол Улсын нийт хүн амын 1 хувь хүрэхгүй хүний гарт төвлөрч байна гэвэл та итгэх үү? Үнэндээ бол тийм.

Хувьцааны ашиг тусыг мэддэг хүмүүс хувьцаа цуглуулж, харин мэддэггүй нь сольж, зарж үгүй хийсэн. Ерээд онд ийм л юм болсон. Ихэнх хүмүүс үнэт цаасны зах зээл гэж юу болох, хувьцаа ямар ашиг тустай болох талаар ойлголтгүйгээсээ болж хөрөнгө оруулалтын эрхийн бичиг болох цэнхэр, ягаан тасалбараа ашиглаж чадаагүй. Иймээс үнэт цаасны зах зээл, хувьцааны талаар ойлголттой болох хэрэгтэй.






1.4. Бонд буюу өрийн хэрэгслийн хөрөнгө оруулалт





Бонд гэж бусдад зээл олгосныг баталгаажуулсан үнэт цаас юм. Өөрөөр хэлбэл, та компанийн эсвэл Засгийн газрын бонд худалдаж авсан бол та компани, Засгийн газарт мөнгөө зээлүүлсэн гэсэн үг.

Таны мөнгийг зээлснийхээ төлөө бонд гаргагч нь тогтмол хүү төлөх ба заасан хугацааны дараа анх зээлсэн мөнгөө /нэрлэсэн үнэ гэх/ эргүүлэн төлөх зарчимтай. Жишээлбэл, та 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилд 5%-ийн хүүтэй 10 жилийн хугацаатай Засгийн газрын бонд худалдаж авсан гэвэл жил бүр 5000 төгрөгийн хүү, 10 жилийн дараа анх зээлсэн 100,000 төгрөгөө эргүүлэн авна гэсэн үг. Гэхдээ богино хугацаатай бондууд ихэвчлэн хямдруулсан үнээр гардаг. Ингэхдээ жилийн 5%-ийн хүүтэй 1 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг хямдруулсан үнээр гаргана гэвэл анх 95,238 төгрөгөөр арилжаалж, хугацааны төгсгөлд 100,000 төгрөгийг байршуулна гэсэн үг.

Бондын давуу тал?

-  Хугацаа тутамд тогтмол хүүгээр төлбөр төлөгдөж, тогтмол орлого олох зарчимтай.
-  Засгийн газрын бонд нь хамгийн эрсдэл багатай.
-  Компанийн бонд нь хувьцаатай харьцуулбал эрсдэл багатай, учир нь компани дампуурах тохиолдолд мөнгөө тэргүүн ээлжид нэхэмжлэх эрхтэй.

Бондын сул тал?

-  Эрсдэл бага байгаагийн хэрээр ашиг нь бага. Компани маш өндөр ашигтай ажилласан ч тогтсон хэмжээгээр хүү төлнө.
-  Компанид хувь эзэмшихгүй.
Зөвхөн анх заасан хугацаанд эзэмшинэ.



Бондыг хэн гаргах вэ?

Бондыг Засгийн газар болон компаниуд гаргаж худалддаг. Аль ч улсын засгийн газар санхүүжилтийн эх үүсвэр олж авах зорилгоор бонд гаргаж болно. Тодорхой хэмжээний мөнгийг хүүтэйгээр эргүүлэн төлөхөөр Засгийн газраас бичгээр гаргасан баталгааг засгийн газрын бонд гэнэ. Өрийн бичиг гэдэг нь тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн өрийн үнэт цаас юм.

Өөрийн эзэмшлийг бусадтай хуваалцах сонирхолгүй, хүү төлөх чадвартай компаниуд бонд гаргадаг. Компанийн бонд нь тодорхой хүүтэй эргүүлэн төлөхийг амласан өрийн бичиг юм. Компанийн бондыг гаргасан хугацаанаас нь хамааруулж, богино (5 хүртэл жил), дунд (5-15 жил), урт хугацааны (15-аас дээш) гэж ангилж болно.

Хүснэгт 5. Хувьцаа бондын ялгаа

Хувьцаа	Бонд
Компани гаргадаг.	Засгийн газар, компани гаргадаг.
Эргүүлж төлөх нөхцөлгүй хөрөнгө оруулалт. Гэхдээ бусдад зарж болно.	Тодорхой хугацааны дараа эргүүлж төлнө. Хугацаа дуусахаас өмнө бусдад зарж болно.
Эзэмшигч нь хувь эзэмшилдээ оногдох ногдол ашиг авна.	Эзэмшигч нь зээлсэн дүн буюу өөрөөр хэлбэл нэрлэсэн үнээс тооцож хүү авна.
Хувьцааны ногдол ашиг компанийн ашигт ажиллагаанаас хамаарах тул тогтмол биш байж болно.	Компанийн ашиг алдагдлаас үл хамааран анх тогтоосон хүүг тогтмол дүнгээр авна.
Хөрвөх чадвар сайтай. Хоёрдогч зах зээл дээр арилжаалагддаг.	Хөрвөх чадвар хувьцаанаас сул. Гэхдээ хүссэн үедээ хоёрдогч зах зээл дээр арилжиж болно.
Компани оршин тогтнох бүх л хугацаанд хүчин төгөлдөр.	Зээлийн хугацаанд хүчин төгөлдөр.
Компани дампуурвал хувьцаа эзэмшигчид өөрт ногдох хөрөнгийг компанийн бүх өр төлбөр, зээлийг барагдуулж дууссаны дараа авна.	Компани дампуурвал зээл олгогчид өөрийн зээлдүүлсэн хөрөнгийг хүүгийн хамт хамгийн түрүүнд авна.
Үнийн өөрчлөлт их.	Үнийн өөрчлөлт бага.
Ашиг өндөр бөгөөд эрсдэл их.	Ашиг бага бөгөөд эрсдэл бага.






ТАНЫ МЭДЛЭГТ:

Монголын анхны өрийн бичиг “Бага болзоот”-ыг 100 ам.долларын нэрлэсэн үнэтэй, жилийн 6 хувийн хүүтэй, олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны арван сарын хорин хүртэл хугацаагаар гаргаж байжээ. 1950 онд Сангийн яамнаас урьд гаргагдсан бүх зээллэгээ нэгтгэн 20 жилийн хугацаатай нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 800000 ширхэг өрийн бичгийг гаргасан байдаг. Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойших хугацаанд Засгийн газраас хэд хэдэн удаа өрийн үнэт цаас гаргаж дотоод болон олон улсын зах зээл дээр арилжаалсан байна. Үүнд: Хөгжлийн банкны Евро бонд, Засгийн газрын Чингис бонд, Самурай бонд гэх мэт.

Бонд нь гаргах болон төлбөр хийх нөхцөл, хөрвөх боломж, эрсдэлийн түвшин гэх зэрэг янз бүрийн онцлог шинжээсээ хамаарч олон төрөл байна. Тухайлбал, хөрвөх бонд, индексжүүлсэн бонд, хөвөгч хүүтэй бонд, хүүгүй бонд, орлогын бонд, евро бонд гэх мэтээр ангилж болно.

Засгийн газрын үнэт цаасны төрлүүд

Засгийн газрын бондыг УИХ-аас зөвшөөрсний үндсэн дээр Сангийн яам гаргадаг. Засгийн газрын бондын арилжаа нь 2015 оны 2 сарын 18-ны өдөр батлагдсан “Өрийн удирдлагын тухай” хуулиар зохицуулагддаг. Засгийн газрын бондыг гаргахад дараах шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

-  Тухайн жилийн төсвийн хуульд тусгасан байх;
-  Гаргах үнэт цаасны үнийн дүн нь энэ хуульд заасны дагуу тухайн төсвийн жилийн зээллэгийн дээд хэмжээнд нийцсэн байх;
-  Стратегийн баримт бичигт нийцсэн байх шаардлагатай



Засгийн газар нь төсвийн түр зуурын дутагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор дараах төрлийн үнэт цаасыг гарган гадаад, дотоод, мөнгөний болон хөрөнгийн зах дээр арилжаалдаг. Үүнд:

1. Засгийн газрын вексель. Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жил ба түүнээс богино хугацаатай өрийн бичиг. Энэхүү вексельд төлбөрийн хугацаа болтол хүү төлдөггүй.
2. Засгийн газрын дунд хугацааны өрийн бичиг. Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жилээс дээш, 10 жилээс доош хугацаатай өрийн бичиг. Энэ нь засгийн газрын вексельтэй харьцуулахад өндөр хүү төлдөг. Хүүг 6 сар тутамд төлдөг.
3. Засгийн газрын бонд. Засгийн газраас гаргасан 10-30 жилийн хугацаатай өрийн бичиг. Сангийн вексель болон нот-той харьцуулахад өндөр хүүтэй. Хүүг 6 сар тутамд төлдөг. Үнэ нь хугацаанаас хамаардаг.
4. Орон нутгийн бонд. Орон нутгийн засаг захиргаанаас гаргасан өрийн бичиг. Энэ төрлийн бондыг улсын болон орон нутгийн чанартай үйл ажиллагаа, сургууль эмнэлэг, зам гүүр г.м төслүүдийг санхүүжүүлэхээр гаргадаг. Онцлог нь: Энэ төрлийн бондын хүү нь орон нутгийн татвараас чөлөөлөгддөг.






Зураг 7. Засгийн газрын бонд худалдан авах үйл явц




1.5. Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох вэ?


Монголын хөрөнгийн бирж дээр ажлын өдөр бүр өглөө 10:00-13:00 цагийн хооронд үнэт цаасны арилжаа явагддаг бөгөөд та хувьцаа, бонд худалдан авах, худалдах замаар энэхүү арилжаанд оролцох боломжтой. Үнэт цаасны арилжаанд оролцохын тулд та:

-  Үнэт цаасны арилжаанд зуучлах үүрэг бүхий үнэт цаасны компани /брокер/-д хандан үнэт цаасны арилжааны дансаа нээлгэсэн байх шаардлагатай.
-  Данс нээлгэсний дараа брокерын компанидаа үнэт цаас худалдах эсвэл худалдаж авах захиалгаа өгнө.
-  Брокер нь таны өгсөн захиалгыг хөрөнгийн биржийн арилжааны системд оруулдаг. Таны захиалгатай үнэ ханш болон тоо хэмжээний хувьд нийцэх захиалга байвал таны захиалга биелэгдэж хэлцэл хийгдэх ба нийцэх захиалга байхгүй тохиолдолд захиалгын санд хадгалагдаж биелэгдэх хүртэл тодорхой хугацаанд хүлээнэ.

БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ДИЛЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Зураг 8. Брокер болон дилерийн үйл ажиллагаа



Үнэт цаасны компани тус бүрийн харилцагчдад үйлчлэх нөхцөл, тухайлбал үйлчилгээний шимтгэл хураамж, арилжаанд онлайнаар алсаас ордог эсэх, арилжаанд идэвхтэй оролцдог эсэх зэрэг нь харилцан адилгүй байдаг тул үнэт цаасны компанийн сонгохдоо үйлчилгээний нөхцөлийг харьцуулан судлах зайлшгүй шаардлагатай юм. Та үнэт цаасны компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас болох www.mse.mn хаягийн “Гишүүн компаниуд” хэсгээс авах боломжтой.



Зураг 9. Хөнгөрийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид



ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь 1995 онд үүсгэн байгуулагдаж өнөөг хүртэл үйл ажиллагаагаа өргөжүүлэн 2015 онд Санхүүгийн зохицуулах хорооноос хүлээн зөвшөөрөгдсөн Монголын үнэт цаасны зах зээл дэх анхны Өөрийгөө зохицуулах байгууллага /ӨЗБ/ болж үйл ажиллагаагаа явуулж байна.

Өөрийгөө зохицуулах байгууллага гэдэг нь төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх ба өөрийн гишүүн байгууллага болон хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдэд мэргэжлийн ёс зүй болон үйлчилгээний хэм хэмжээг тогтоож, түүнийг хэвшүүлэхэд чиглэдэг. Ингэснээр Холбоо нь мэргэжлийн оролцоог бий болгож хөрөнгийн зах зээл дэх итгэлийг бий болгон хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах болно.

Холбоо нь нийт 58 гишүүн байгууллагатай бөгөөд үүнд ҮЦК, ХОМК, МХБ, ҮЦТХТ, АТТ, Кастодион банкууд орно.



Монголын Хөрөнгийн Бирж

Монголын хөрөнгийн бирж (МХБ) нь 1991 онд, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш улсын хөрөнгийг хувьчлах зорилгоор байгуулагдсан. МХБ нь 100 хувь төрийн өмчит байгууллага бөгөөд Сангийн яам нь Засгийн газрын өмчлөх эрхийг хэрэгжүүлдэг. Тиймээс МХБ-ийн удирдлагыг Сангийн яамнаас томилж, Сангийн яаманд тайлагнадаг. МХБ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу СЗХ-оос олгосон үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зах зээлийн оролцогчоор зохицуулагддаг.



Монголын Үнэт Цаасны Клирингийн төв

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэх төв (МҮЦКТ) нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн тооцоо, тооцоо, тооцооны компанийг 2015 онд өөрчлөн зохион байгуулах тухай Засгийн газрын 1447 тоот тогтоолоор 2016 онд бие даасан клиринг, төлбөр тооцооны байгууллага хэлбэрээр байгуулагдсан. МҮЦКТ нь 100 хувь төрийн мэдэлд байдаг тул МҮЦКТ нь -ийн удирдлагыг Сангийн яамнаас томилж, Сангийн яаманд тайлагнадаг. МҮЦКТ нь СЗХ-оос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл бүхий зах зээлийн оролцогчоор зохицуулагддаг.

МҮЦКТ нь үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоог Монголбанкны бодит цагийн нийт төлбөр тооцооны системээр явуулдаг. Монголбанкны төлбөр тооцооны системийг ашигладаг тул дангаараа дотоодын арилжаагаар хийгдсэн улсын өрийн үнэт цаасыг бус зөвхөн олон нийтэд гаргасан корпорацийн өрийн үнэт цаасыг барагдуулах үүрэгтэй.



Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв

Засгийн газрын 2003 оны 72 дугаар тогтоолоор үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг бүртгэх, үнэт цаасны төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны төлбөр тооцоо хийх зорилгоор Сангийн яамны дэргэд Монголын үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийг байгуулсан. ҮЦТХТ нь 100% төрийн өмчит бөгөөд үүнтэй холбогдуулан ҮЦТХТ-ын удирдлагыг Сангийн яамнаас томилж, Сангийн яаманд тайлагнадаг. ҮЦТХТ нь СЗХ-оос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл бүхий зах зээлийн оролцогчоор зохицуулагддаг.



Үнэт цаасны бирж

Хувийн үнэт цаасны бирж болох Монголын үнэт цаасны бирж (MSX) нь 2015 оны 5-р сард байгуулагдсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 7-р сарын 312 тоот тогтоолоор үнэт цаасны зах зээл дээр зохицуулалттай бирж ажиллуулах тусгай зөвшөөрөл авсан. MSX-ийн арилжааны системийг Nasdaq Inc компани хангаж байгаа бөгөөд 2019 оны байдлаар 14 үнэт цаасны компаниудын арилжаа эрхэлдэг.



Үнэт цаасны компани

Үнэт цаасны компани гэдэг нь Харилцагч буюу Иргэд, ААН-үүдэд Хөрөнгийн бирж дээрээс хувьцаа, бонд худалдан авахад зуучилдаг мэргэжлийн байгууллага юм. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Үнэт цаасны компаниуд Брокер, Дилер, Андеррайтер болон Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байдаг.

Брокерийн үйлчилгээ

Харилцагчийн нэрийн өмнөөс, түүний захиалгын дагуу үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагаа юм.

Дилерийн үйл ажиллагаа

Өөрийн нэрийн өмнөөс өөрийн хөрөнгөөр үнэт цаасыг худалдах, худалдан авах үйл ажиллагаа

Андеррайтерийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа

Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ

Үнэт цаас гаргагчийн нийтэд танилцуулагдсан мэдээлэлд үндэслэн судалгаа, шинжилгээг гүйцэтгэх, харилцагчид үнэт цаасыг худалдах, худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар мэргэжлийн зөвлөгөөг

Үнэт цаасны дансаа хэрхэн нээх вэ?

Баримт бичиг /Иргэн/ + данс нээсний төлбөр + дансны гэрээ (үнэт цаас болон эскроу)



Иргэний үнэмлэх



Хүүхэд бол төрсний гэрчилгээ болон эцэг эхийн аль нэгний иргэний үнэмлэх







Гадаад иргэн бол гадаад паспорт /эзэмшигчийн гарын үсэг болон паспортын хүчинтэй хугацаа бүхий хуудаснуудын хуулбар/

Үнэт цаасны арилжаанд хэрхэн орох вэ?

Заавал брокерын компаниар зуучлуулах шаардлагатай.





Үнэт цаасны зах зээлд хөл тавихад анхаарах зүйлс


-  Шинэ мэдлэг, мэдээллээр өөрийгөө үргэлж цэнэглэ – Хөрөнгө оруулалтын үндсэн зорилго нь өгөөж хүртэх хэдий ч мөнгө олохын төлөө бүү яар.
-  Тэвчээртэй, тууштай бай – Алдагдал хүлээх үедээ болон ашиг олох үедээ сэтгэлзүйгээ зөв удирд.
-  Алдагдал хүлээсэн бол шалтгааныг нь олж, гаргасан алдаанаасаа суралц – хөрөнгө оруулалтын багцаа тухай бүр шинэчил.
-  Өөрийн хэрэглээнээс илүү гарсан мөнгөөр арилжаанд оролц – Хэзээ ч бүү зээл авч хөрөнгө оруулалт хий.



Initial Public Offering- Анхдагч зах зээлийн арилжаа /IPO/

-  Энэ нь үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь хөрөнгө хуримтлуулах, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгыг агуулж байдаг.
-  Мөн үнэт цаас гаргагчаас үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50-иас дээш тооны этгээдэд санал болгож хувьцаагаа биржээр дамжуулж нээлттэй худалдахаа мэдэгдэхийг хэлнэ.

Хороонд бүртгүүлээгүй аливаа үнэт цаасыг нийтэд санал болгон сурталчлах, үнэт цаасны зах зээлд арилжихыг хориглодог.



ХУВЬЦААТ КОМПАНИ БАЙХЫН ДАВУУ ТАЛУУД

ХӨРӨНГӨ БОСГОХ

- Хүссэн үедээ хямд өртөгтэй, урт хугацаат санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх боломжтой.
- Зээл авснаас илүү хэмжээний капитал хуримтлуулах боломжтой

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ САЙЖРАХ

- Нэр хүнд өснө
- КЗ-ын сайн тогттолцоо бүрдэнэ.
- Чадварлаг боловсон хүчин, сайн менежментийн баг бүрдүүлэх боломжтой.

БУСАД





- Зах зээлийн үнэ цэнэ бодитой тодорхойлогдоно.
- Гадаадын зах зээлээс санхүүжилт татах боломжтой.
- Бонд гаргахад нөхцлөө өөрөө тодорхойлно



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-НЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2012 оны ЗГ-ын 181-р тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийт хувьцаанаас 2012 оны дөрөвдүгээр сарын 11-ээс өмнө төрсөн Монгол улсын иргэдэд эзэмшүүлэхээс гадна ААН-үүдэд худалдахаар заасан.

Нийт 15 тэрбум ширхэг хувьцаатай. Үүнээс:

-  Төр 85.2%-12,8 тэрбум ширхэг
-  Иргэд 14,75%-2,2 тэрбум ширхэг
-  ААН 0,05%-7,6 сая ширхэг
-  Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 933 төгрөг

Хувьцаагаа зарж болох уу?

Хариулт: Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоол

“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн хоёр дахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд хувьцааг саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгөөр иргэд, ААН-д эзэмшүүлсэн тул болохгүй. Хөрөнгийн биржийн арилжаа эхэлсэн тохиолдолд зарах боломжтой.

Нас барсан иргэдийн хувьцааг яах вэ?

Хариулт: Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолын дагуу харахан энэхүү боломж олгогдоогүй байгаа.

Ногдол ашиг авч болох уу?

Хариулт: Цэвэр ашигтай ажилласан тохиолдолд л ногдол ашиг тарааж болохыг хуулиар заасан байдаг. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар өмнөх жилийн үйл ажиллагааг дүгнэж, ногдол ашиг тараах эсэх шийдвэрийг гаргана.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих

Хөрөнгийн зах зээл хөгжсөнөөр дэд бүтэц, үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар макро болон микро эдийн засаг, нийгмийн суурь үзүүлэлтүүдийн тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлдэг.

Санхүүгийн зах зээлд өрсөлдөөнийг нэмэгдүүлж, хөгжих боломжийг бүрдүүлнэ

Санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх байр суурь нэмэгдсэнээр санхүүжилтийн эх үүсвэрийн өртөг буюу банкны хүү буурдаг. Түүнчлэн компаниуд хөрөнгийн зах зээлээс эх үүсвэр татсанаар урт хугацаанд хөгжих боломжоо нээдэг ба ингэснээр үндэсний хэмжээний томоохон корпорациудын суурийг бий болгодог.

Хөрөнгө оруулалтыг дэмжих, хуримтлалыг нэмэгдүүлэх

Хөрөнгийн зах зээлээр дамжин хийгдэх хөрөнгө оруулалт, санхүүжилт нь улс орнуудын Засгийн газарт болон компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлж, санхүүгийн зуучлалыг нэмэгдүүлснээр эргээд хуримтлал бий болгох боломжийг бүрдүүлдэг.

Хөрөнгийг зохистой хуваарилах

Хөрөнгийн зах зээл хөгжсөнөөр хөрөнгийн зохистой хуваарилалтыг дэмждэг бөгөөд үнэт цаасны үнэ ханшийн өөрчлөлт нь тухайн бизнесийн салбар болон байгууллагад хөрөнгийн урсгалыг бий болгож байдаг.

Эрсдэлийн тараан байршуулах

Хөрөнгө оруулагчдад эрсдэлд суурилсан өгөөжийг байнга санал болгож байдаг бөгөөд хөрөнгөө үр ашигтай байршуулах, эрсдлээ удирдах боломжийг олгож байдаг.

Компанид сайн засаглал, ил тод байдлыг бий болгох

Компаниудын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналыг ил тод болгож, компанийн үйл ажиллагаа, удирдлагад сайн засаглалыг төлөвшүүлдэг.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ДААТГАЛ



1. Даатгал, түүний ач холбогдол

Даатгал гэж юу вэ?

Хүн бүр амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөө хамгаалахын тулд учирч болох эрсдэлээс сэргийлдэг хэдий ч "Гай газар дороос" гэдэг шиг аливаа өвчин зовлон, аюул осол хэлж ирдэггүй хийсэж ирдэг. Энэ үед хүн сэтгэл санааны, бие махбодийн, эд хөрөнгийн хохирол амсаж, түүнийг барагдуулах, даван туулахад тодорхой хэмжээний санхүүгийн дарамт үүсдэг.

Иймээс аливаа хувь хүн, албан байгууллагын хэвийн байдлыг алдагдуулах, санамсаргүй, эрсдэл дагуулсан үйл явцаас үүсэх хохирлыг бууруулах, нөхөх санхүүгийн үр дүнтэй арга хэрэгсэл бол даатгал юм.

Хүмүүс хэсэг бүлгээрээ дундын сан бүрдүүлж, тэрхүү сангаасаа хохирол учирсан нэгэндээ туслах нь даатгалын үндсэн хэлбэр юм. Тэрхүү санг үүсгэхэд хамтарч оролцох хүмүүсийн тоо олон байх тусам нэг хүнд ногдох зардлын хэмжээ буурдаг бөгөөд учирсан хохирлыг барагдуулахад хүрэлцэхүйц байх боломжтой. Үүнтэй адил даатгал бол бага зардал гарган их хэмжээний хохирлоос хамгаалагдах боломж буюу хариуцлага, хамгаалалт, амар тайван байдлыг эрэлхийлсэн эрсдлийн удирдлагын энгийн шийдэл гэж ойлгож болно.



Гэнэтийн
өвчин



Ердийн
өвчин



Архаг хууч
өвчин



Зам
тээврийн
осолд өртөх
эрсдэл



Бусдад
хорлогдох
эрсдэл



Араатан
амьтны
нөлөөгөөр
үүсэх эрсдэл



Техникийн
эрсдэл



Ахуйн
эрсдэл



Байгалийн
эрсдэл

Гэнэтийн эрсдэл хэнд ч, хэзээ ч тохиолдох магадлалтай тул түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, шилжүүлэх, хүлээн зөвшөөрөх зэрэг арга хэмжээг авч болох бөгөөд учирч болзошгүй хохирлыг бусдад шилжүүлэх буюу даатгалд хамрагдах боломж байдаг. Эрсдлийг даатгагдах болон даатгагдахгүй эрсдэл гэж ангилдаг. Гэнэтийн шинж чанартай, хохирол нь мөнгөөр илэрхийлэгдэх боломжтой эрсдлийг даатгагдах эрсдэл гэдэг



Даатгуулж болох эрсдлийн төрлүүд



Хувь хүний эрсдэл - Амь нас, эрүүл мэнд учирч болзошгүй эрсдлүүд.
Жишээ нь: автомашины осолд өртөх, өвчин тусах г.м.



Эд хөрөнгийн эрсдэл - Таны эд хөрөнгөд бүрэн буюу хэсэгчлэн хохирол учруулж болзошгүй эрсдлүүд.
Жишээ нь: хулгайд юмаа алдах, орон гэр нь гал түймэрт өртөх г.м.



Хариуцлагын эрсдэл - Аливаа хариуцлагагүй болон санаандгүй үйлдлээс болж бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй эрсдлүүд.
Жишээ нь: автомашин жолоодож байхдаа бусдыг гэмтээх, эд хөрөнгөд нь хохирол учруулах г.м.



Даатгалд хамрагддаггүй эрсдлийн төрлүүд:



Элэгдэл, хорогдол



Техникийг шалган турших явцад гарах хохирол



Хувь хүний сэтгэл санааны хохирол, байгууллагын нэр хүндийн эрсдэл

Даатгал нь даатгалын гэрээний үндсэн дээр иргэд, байгууллагууд эрсдлээ даатгуулж даатгалын хураамж төлөх, гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол болсон үед даатгалын компаниас нөхөн төлбөр олгох итгэлцэл дээр суурилдаг үйл ажиллагаа юм. Иймд иргэн та даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцаа болон даатгалтай холбогдох дараах үндсэн ухагдахууныг ойлгох нь зүйтэй.


Хүснэгт 1. Даатгалтай холбоотой үндсэн ухагдахуун

№	Нэр томъёо	Тодорхойлолт
1.	Даатгал	Ирээдүйд учирч болох аливаа эрсдлийг шилжүүлэх, багасгахад чиглэсэн үйл ажиллагаа
2.	Даатгалын зүйл	Даатгалд хамрагдаж байгаа эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхол
3.	Даатгалын гэрээ	Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх даатгалын харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг
4.	Даатгалын үнэлгээ	Даатгалын объектыг үнэлж, мөнгөн дүнгээр илэрхийлсэн хэмжээ
5.	Даатгалын тохиолдол	Даатгуулсан зүйлд учирсан хохирол, гэрээнд заасан болзол бүрдэхийг
6.	Даатгалын хураамж	Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөр бөгөөд даатгалын үнэлгээнээс хамаарч хураамжийг тооцдог
7.	Даатгалын нөхөн төлбөр	Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө
8.	Даатгалын баталгаа	Даатгалын компаниас даатгасныг баталгаажуулан даатгуулагчдаа өгч буй баримт бичиг бөгөөд даатгалын гэрээний салшгүй хэсэг юм
9.	Даатгалын хугацаа	Даатгалын гэрээнд заасан хүчинтэй хугацаа

2. Даатгалын харилцаанд оролцогчид, хууль эрх зүйн зохицуулалт

Даатгалын үйл ажиллагаа нь даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй харилцаа юм. Энэхүү харилцаанд даатгагч, даатгуулагчаас гадна даатгалын мэргэжлийн оролцогчид, төрийн байгууллагууд оролцдог.

Даатгалын тухай хуульд зааснаар даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам даатгалын бодлогыг, Санхүүгийн зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлдэг бол, “Даатгалын тухай хууль” болон “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль”-ийн дагуу даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогчид буюу даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч нь Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлдэг.



Зураг 1. Даатгалын харилцаанд оролцогчид
Хүснэгт 2. Даатгалын харилцаанд оролцогчид

№	Оролцогч	Тодорхойлолт
1	Санхүүгийн зохицуулах хороо	Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл олгох, даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлэх
2	Даатгагч	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани
3	Даатгуулагч	Өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгалын гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээд
4	Даатгалын төлөөлөгч	Даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс гэрээ хэлцэл хийх эрх бүхий этгээд
5	Даатгалын зуучлагч	Даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө гэрээ хэлцэл хийх эрх бүхий этгээд
6	Даатгалын хохирол үнэлэгч	Даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, даатгалын тохиолдлын бодит хохирлын хэмжээг тогтоох хараат бус этгээд
7	Давхар даатгагч	Даатгалын компанийн эрсдэл хариуцах үүргийг давхар даатгасан буюу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани



Даатгуулагч нь даатгалын компанийн салбар нэгжид хандан даатгуулахаас гадна даатгалын төлөөлөгч, зуучлагчаар дамжуулан даатгалын гэрээ байгуулах боломжтой юм. Та даатгуулагчийн хувьд зөвлөгөө авахыг хүсвэл даатгалын компанийн ажилтан, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчид хандаж болно.

Хүснэгт 3. Даатгалын харилцааг зохицуулдаг хуулиуд

№	Хуулийн нэр	Батлагдсан он	Хамрах хүрээ
1	Даатгалын тухай	2004-04-30	Даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах
2	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай	2004-04-30	Даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулах
3	Жолоочийн даатгалын тухай	2011-10-6	Жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах
4	Малын индексжүүлсэн даатгалын тухай	2014-06-13	Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, төрөөс тавих хяналт, даатгалын эрсдлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, малын давхар даатгал, даатгагч болон даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах
5	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай	2005-11-17	Санхүүгийн зохицуулах хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулах
6	Иргэний хууль	2002-01-10	Иргэний хуулийн 43-р бүлэгт даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг зохицуулах

3. Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ

Даатгалын тухай хуульд зааснаар даатгалыг урт хугацааны ба ердийн даатгал гэж ангилах бөгөөд ангилал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна. Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтоодог бол сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.

Хувь хүн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр даатгуулах эсэх нь сонголттой бол сайн дурын даатгал, харин аливаа үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд заавал даатгуулахаар хуульчилсныг албан журмын даатгал гэнэ.

Хүснэгт 4. Даатгалын ангилал

№	Даатгалын ангилал, төрөл	Тодорхойлолт	Жишээ
Ангиллаар нь	Ердийн даатгал	Аливаа гэнэтийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эдийн бус ашиг сонирхолд учрах эрсдлээс хамгаалах, богино хугацаатай, амьдралын бус даатгал	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын, эд хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, ачааны, барилга угсралтын, газар тариалангийн, мал амьтдын даатгал г.м
	Урт хугацааны даатгал	Хүний амь нас, эрүүл мэндэд учрах эрсдлээс хамгаалах, амьдралын баталгаатай холбоотой санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх, урт хугацаатай, амьдралын даатгал	Хугацаат амьдралын, насан туршийн, хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн г.м
Төрлөөр нь	Албан журмын	Хуульд заасны дагуу заавал даатгуулах даатгал	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
	Сайн дурын	Иргэн, хуулийн этгээдүүд өөрийн хүсэлтийн үндсэн дээр даатгуулж болох даатгал	Хуульд заавал даатгуулах гэж зааснаас бусад даатгал



Жишээлбэл, Иргэн А авто машин жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ санамсаргүй бусдын авто машиныг мөргөж гэмтээх тохиолдолд гуравдагч этгээдэд учруулсан хохирлоо жолоочийн хариуцлагын даатгалаар нөхөн төлүүлж болно. Харин тээврийн хэрэгслийн даатгалд даатгуулсан бол өөрийн авто машинд учирсан хохирлыг барагдуулж болох юм. Үүнээс машин барьж авто замын хөдөлгөөнд оролцдог л бол жолооч та жолоочийн хариуцлагын даатгалд заавал даатгуулах учиртай, харин тээврийн хэрэгслээ даатгуулах эсэх нь таны сонголт юм.

Хүснэгт 5. Даатгалын хэлбэр, тодорхойлолт


(Хуулиар болон СЗХ-оос тогтоосон нийт даатгалын хэлбэрээс дараах хэлбэрүүдийг сонгож тайлбарласан болно)

№	Даатгалын төрөл	Агуулга
1.	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	Аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчаас даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдахтай холбоотой эмнэлэг, эмчилгээ, мэс заслын зэрэг зардлын даатгал хамаарна
2.	Автотээврийн хэрэгслийн даатгал	Автотээврийн хэрэгслийг эзэмших, ашиглах үед тухайн тээврийн хэрэгсэлд хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Тээж яваа ачаа болон аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй
3.	Хариуцлагын даатгал	Аливаа этгээдийн санамсар болгоомжгүй буруутай үйлдлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал
4.	Санхүүгийн даатгал	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Бизнес тасалдлын даатгал үүнд хамаарна
5.	Жолоочийн хариуцлагын даатгал	Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахад даатгагчаас хохирогчид мөнгөн төлбөр төлөх, хохирогчийн эрхийг хамгаалах нөхцөл бүхий даатгал
6.	Эрүүл мэндийн даатгал	Эрүүл мэндийн холбогдолтой зардлыг даатгалын гэрээгээр даатгуулагчид төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал хамаарна

7.	Тэтгэврийн даатгал	Даатгалын гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгуулагчид тэтгэвэр буюу мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал
8.	Хуримтлалын даатгал	Даатгуулагч гэрээт хугацааны эцэст амьд байх болон тухайн хугацаанаас өмнө нас барах гэсэн нөхцөлүүдээр даатгуулагч, эсвэл гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч баталгаатай мөнгөн төлбөр төлөх хугацаат болон хөрөнгө оруулалтын хавсарсан даатгал. Гэрлэлтийн, сургалтын зардлын, орон сууцны хуримтлалын даатгал үүнд хамаарна

Даатгалын хэлбэр нь даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэх бөгөөд даатгалын бүтээгдэхүүн нь даатгагчаас хэрэглэгчдэд санал болгож, худалдан борлуулж байгаа даатгалын үйлчилгээг ойлгоно. Жишээлбэл, хүүхдийн гэнэтийн ослын даатгал, хашаа, байшингийн даатгал, гадаадад зорчигчийн даатгал, хүүхдийн боловсролын хуримтлалын даатгал г.м.

Даатгалын компаниудын санал болгодог олон төрлийн даатгалын бүтээгдэхүүнээс хэрхэн сонголт хийх талаарх зөвлөгөөг дараах зургаас харж болно.






Зураг 2. Даатгалын компани сонгох алхмууд







4. Даатгалын тохиолдол гарах, нөхөн төлбөр авах

Хэрэв даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол гарсан бол хохирлыг нөхөх үүргийг даатгагч хүлээдэг. “Даатгалын тухай хууль”, “Иргэний хууль” болон даатгалын гэрээнд даатгагч, даатгуулагчийн эрх, үүргийг тодорхой заасан байдаг бөгөөд ялангуяа даатгуулагч өөрийн хүлээх үүргээ маш сайн мэддэг байх нь чухал юм. Тухайлбал, даатгалын тохиолдол болсон үед тодорхой хугацааны дотор даатгагчдаа мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас нөхөн төлбөр авч чадахгүй нөхцөл үүсэх юм.







Даатгалын бүтээгдэхүүнээс хамаарч даатгалын тохиолдол янз бүр байх ба үүнээс хамаарч даатгуулагчийн зүгээс авах арга хэмжээ ч өөр байна. Тухайлбал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тохиолдлын үед та:

-  Замын цагдаа, даатгалын компанидаа дуудлага өгөх;
-  Ослын улмаас хүн бэртэж, гэмтсэн бол яаралтай түргэн тусламж дуудах;
-  Хэрэв дуудлага өгөх боломжгүй нөхцөлд байгаа тохиолдолд ямар нэг байдлаар тохиолдлыг батлагаажуулах арга хэмжээ авах. Жишээ нь, орчин нөхцөлийг оролцуулан ослын зураг авах, бичлэг хийх г.м;

Даатгуулагч даатгалын хохирлыг нөхөн төлүүлэхийн тулд даатгагчийн шаардсан баримтыг бүрдүүлнэ. Даатгуулагчийн бүрдүүлэх баримт нь даатгалын төрлөөс хамаарч өөр өөр байх боловч дараах нийтлэг баримтууд шаардлагатай байдаг. Үүнд:

-  Даатгалын баталгааны эх хувь;
-  Даатгуулагчийн өргөдөл;
-  Учирсан хохирлын тухай эрх бүхий этгээдийн гаргасан дүгнэлт, акт материал;
-  Шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт (Эмнэлэг, эмчийн магадлагаа, цагдаагийн тодорхойлолт г.м);

Дараах тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзаж болно. Үүнд:

-  Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;
-  Даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
-  Даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;
-  Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
-  Даатгуулагч хүндэтгэх шалтгаангүйгээр хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол, тухайлбал даатгалын тохиолдлын талаар заасан хугацаанд даатгагчид мэдэгдээгүй, нөхөн төлбөр авах хүсэлт, бичиг баримтаа бүрдүүлж өгөөгүй г.м;
-  Дайн байлдаан, хувьсгал, төрийн эргэлт, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, бослого, үймээнд оролцсоны улмаас үүссэн хохирлыг төлөхгүй;

Даатгагч, даатгуулагчийн хооронд маргаан үүссэн, даатгалын компани нөхөн төлбөрийг бүрэн эсвэл хэсэгчлэн олгохоос татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргаан гарсан тохиолдолд СЗХ-д өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

Хэрэв аль нэг тал нь СЗХ-ны шийдвэрийг зөвшөөрөөгүй бол шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.



